



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/02/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Албан шаардлага .....	14
4.3 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

## 1.Аудитын дүгнэлт

АРХАНГАЙ АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,601,260.00	10,770,720.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,601,260.00	10,770,720.00
35400	Хангамжийн материал	1,601,260.00	10,770,720.00
35420	Аж ахуйн материал	1,601,260.00	1,369,720.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	9,401,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,843,215.30	44,856,545.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,843,215.30	44,856,545.32
39200	Биет хөрөнгө	25,843,215.30	44,856,545.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	163,700,000.00	163,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-155,450,000.00	-158,750,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	18,877,539.30	44,025,885.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,481,381.26	-11,599,955.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,577,189.00	50,698,189.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,380,131.74	-43,217,573.76
39301	Програм хангамж	5,860,000.00	5,860,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,860,000.00	-5,860,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	27,444,475.30	55,627,265.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,444,475.30	55,627,265.32
51	Засгийн газрын хувь оролцоо	27,444,475.30	55,627,265.32
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	104,702,634.31	104,702,634.31
51200	Хуримтлагдсан үр дүн	-78,115,740.01	-49,932,949.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-71,860,894.48	-78,115,740.01
51220	Тайлант үеийн үр дүн	-6,254,845.53	28,182,790.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	857,581.00	857,581.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	27,444,475.30	55,627,265.32

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	854,430,500.00	686,858,446.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	10,674,546.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	10,674,546.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	10,674,546.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,430,500.00	676,183,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	366,000,000.00	58,460,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	366,000,000.00	58,460,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	488,430,500.00	617,723,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	488,430,500.00	617,723,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	858,385,225.43	658,675,655.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	858,385,225.43	658,675,655.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,255,344.27	535,414,715.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,901,460.99	224,514,506.60
210101	Үндсэн цалин	147,021,621.99	155,852,363.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,079,839.00	16,990,242.40
210105	Гэрээт ажлын хөлс	10,800,000.00	51,671,900.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,526,627.34	27,961,260.73
210201	Тэтгэврийн даатгал	14,871,788.44	20,351,301.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,643,535.05	1,847,093.44

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,437,568.33	1,443,754.70
210204	Ажилгүйдлийн даатгал	334,480.93	301,507.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,254.59	4,017,603.66
2104	Хангамж, бараа материалын зардал	37,285,040.50	26,086,978.89
210401	Бичиг хэрэг	2,760,000.00	3,670,484.00
210402	Тээвэр, шатахуун	29,000,000.00	15,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,340,000.00	3,245,925.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,868,540.50	3,570,569.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,800,000.00	9,876,000.00
210604	Урсгал засвар	10,800,000.00	9,876,000.00
2107	Томиллолт, зочны зардал	24,050,600.00	11,192,468.00
210702	Дотоод албан томиллолт	2,052,000.00	2,790,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,998,600.00	8,402,468.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	396,235,760.00	210,621,345.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	393,989,368.00	208,573,187.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,392.00	154,158.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,455,855.44	25,162,155.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,394,470.00	16,906,139.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,061,385.44	8,256,015.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,129,881.16	123,260,940.98
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	78,000,000.00	117,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	78,000,000.00	117,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,750,300.00	3,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,297,500.00	3,450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	379,581.16	2,810,940.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	379,581.16	2,810,940.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-3,954,725.43	28,182,790.02
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,254,845.53	28,182,790.02

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-71,860,894.48	33,699,320.83
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-71,860,894.48	33,699,320.83
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,254,845.53	-6,254,845.53
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-78,115,740.01	27,444,475.30
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-78,115,740.01	27,444,475.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-78,115,740.01	27,444,475.30
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	28,182,790.02	28,182,790.02
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	104,702,634.31	857,581.00	-49,932,949.99	55,627,265.32

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	854,430,500.00	676,183,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	854,430,500.00	676,183,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	366,000,000.00	58,460,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	366,000,000.00	58,460,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	488,430,500.00	617,723,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	488,430,500.00	617,723,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	849,010,500.00	659,589,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	849,010,500.00	659,589,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,880,618.84	536,178,159.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,181,461.00	224,514,506.60
210101	Үндсэн цалин	147,021,622.00	155,852,363.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,079,839.00	16,990,242.40
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	51,671,900.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,526,625.34	27,961,260.73
210201	Тэтгэврийн даатгал	14,871,788.44	20,351,301.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,643,533.05	1,847,093.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,437,568.33	1,443,754.70
210204	Ажилгүйдлийн даатгал	334,480.93	301,507.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,254.59	4,017,603.66
2104	Хангамж, бараа материалын зардал	35,966,200.50	25,445,925.69
210401	Бичиг хэрэг	2,760,000.00	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,000,000.00	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,340,000.00	3,245,925.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,866,200.50	3,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,800,000.00	9,834,000.00
210604	Урсгал засвар	10,800,000.00	9,834,000.00
2107	Томилт, зочны зардал	24,050,600.00	11,299,908.00
210702	Дотоод албан томилт	2,052,000.00	2,790,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,998,600.00	8,509,908.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,227,162.00	220,462,558.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	394,980,770.00	218,414,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,392.00	154,158.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,128,570.00	16,660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,128,570.00	16,660,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,129,881.16	123,410,940.98
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	78,000,000.00	117,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	78,000,000.00	117,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,750,300.00	3,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,297,500.00	3,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	379,581.16	2,810,940.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	379,581.16	2,810,940.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,420,000.00	16,594,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,420,000.00	16,594,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,420,000.00	16,594,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,420,000.00	16,594,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,420,000.00	16,594,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,420,000.00	-16,594,800.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	617,723,900.00	614,912,959.02	2,810,940.98	99.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,723,900.00	614,912,959.02	2,810,940.98	99.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,123,900.00	494,312,959.02	2,810,940.98	99.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,732,000.00	224,514,506.60	217,493.40	99.9
210101	Үндсэн цалин	155,980,000.00	155,852,363.30	127,636.70	99.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,080,000.00	16,990,242.40	89,757.60	99.47
210105	Гэрээт ажлын хөлс	51,672,000.00	51,671,900.90	99.10	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,339,700.00	27,961,260.73	2,378,439.27	92.16
210201	Тэтгэврийн даатгал	21,350,400.00	20,351,301.68	999,098.32	95.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,247,300.00	1,847,093.44	400,206.56	82.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,797,900.00	1,443,754.70	354,145.30	80.3
210204	Ажилгүйдлийн даатгал	449,500.00	301,507.25	147,992.75	67.08
210205	Эрүүл мэндийн даатгал	4,494,600.00	4,017,603.66	476,996.34	89.39
2104	Хангамж, бараа материалын зардал	25,530,000.00	25,445,925.69	84,074.31	99.67
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,600,000.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	15,000,000.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,330,000.00	3,245,925.69	84,074.31	97.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	3,600,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	15,936,000.00	64,000.00	99.6
210602	Тавилга	6,000,000.00	5,936,000.00	64,000.00	98.93
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	11,310,000.00	11,299,908.00	10,092.00	99.91
210702	Дотоод албан томилолт	2,800,000.00	2,790,000.00	10,000.00	99.64
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,510,000.00	8,509,908.00	92.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,212,200.00	181,155,358.00	56,842.00	99.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,107,200.00	179,107,200.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	154,158.00	25,842.00	85.64
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	44,000.00	31,000.00	58.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	8,000,000.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,600,000.00	120,600,000.00	0.00	100

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлангийн аудитын тайлан

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	117,000,000.00	117,000,000.00	0.00	100
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	117,000,000.00	117,000,000.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,600,000.00	3,600,000.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	3,600,000.00	0.00	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	617,723,900.00	614,912,959.02	2,810,940.98	99.54
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	318,923,900.00	614,912,959.02	-	192.8
320001	Орон нутгийн төсвөөс	318,923,900.00	614,912,959.02	-	192.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	298,800,000.00	0.00	298,800,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	298,800,000.00	0.00	298,800,000.00	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23.00	29.00	-6.00	126.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	14.00	-3.00	127.3
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	12.00	-3.00	133.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	14.00	14.00	-3.00	127.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	6.00	2.00	75
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	7.00	-5.00	350
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,460,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,460,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,460,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,660,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,460,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,460,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,460,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн ИТХ нь Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон, хэрэгжүүлэхэд иргэдийн бүтээлч санаачилга, идэвхтэй оролцоо төлөөлөх эрхийг нэмэгдүүлэн, хүний хөгжлийг бүх талаар хангах боломж нөхцөлийг бий болгох, нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, бие даасан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн зорилго оршино” гэсэн зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 617.7 сая төгрөгөөс 1%-иар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 28.2 сая төгрөгөөр буюу 50.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Бараа материал	1.6	10.8	9.2	85.2
Үндсэн хөрөнгө	25.8	44.8	19.0	42.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>27.4</b>	<b>55.6</b>	<b>28.2</b>	<b>50.7</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	27.4	55.6	28.2	50.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27.4</b>	<b>55.6</b>	<b>28.2</b>	<b>50.7</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 9.2 сая төгрөгөөр буюу 85.2 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 1.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 39.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 30.5 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 10.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 19.0 сая төгрөг буюу 42.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 25.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 16.6 сая төгрөг, хандив тусламжаар ирсэн 10.7 сая төгрөг нийт 27.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 8.2 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 44.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 28.2 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

## Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт Б	Өмнөх он 1	Тайлант он 2	Өөрчлөлт 3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	488.4	617.7	129.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	366	58.5	-307.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10.7	10.7
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>854.4</b>	<b>686.9</b>	<b>-167.5</b>
Бараа үйлчилгээний зардал	753.2	535.4	-217.8
Урсгал шилжүүлэг	105.1	123.3	18.2
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>858.3</b>	<b>658.7</b>	<b>-199.6</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-3.9</b>	<b>28.2</b>	<b>32.1</b>

Архангай аймгийн ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 129.3 сая төгрөг буюу 19.6%-иар буурсан нь нэмэлт санхүүжилтээр ирсэн санхүүжилт буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 751.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 134.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 617.7 сая төгрөгөөр хянаж баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 617.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 617.7 сая төгрөгийн санхүүжилт авч 614.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 2.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас 2.5 сая төгрөг, бусад зардлаас 0.3 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 84.2 сая төгрөгийн орлого ирснийг дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

1. ЦАУЗБУК-оос ирсэн 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг цагаатгалын нөхөн олговрыг иргэн О.Жавзандуламд шилжүүлсэн байна.
2. ГХУСАЗ-өөс ирсэн 7.8 сая төгрөгийн санхүүжилтийг 19 сумын ИТХ-ын ажлын албанд шилжүүлж, онлайн сургалт зохион байгуулсан байна.
3. НҮБ-аас ирсэн 8.7 сая төгрөгийн санхүүжилтийг 19 сумын хүүхэд хамгааллын багт шилжүүлсэн байна
4. Аймгийн засаг даргын А/408 тоот захирамжаар 2.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг өмгөөлөгчийн хөлсөнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Аудитын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1. Архангай аймгийн ИТХ "Төлөөлөгчийн нэг өдөр", "Төлөөлөгчийн индэр" нэвтрүүлэг, Хороодын хэлэлцүүлгийг АВ ТВ-тэй хамтран зохион байгуулсан байна. Мөн 19 сумын ИТХ-ын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж зөвлөмж өгч аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг чадавхжуулах сургалтыг 7 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 900 гаруй төлөөлөгчийг хамруулсан байна.
2. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 50 арга хэмжээг санхүүжүүлэхээр 158.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэл 100%-тай байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 95.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 617.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 614.9 сая төгрөгийг зарцуулж, 99.6 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Батлагдсан төсвөөс 2.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн
- Зочин төлөөлөгч хүлээн авахад 8.5 сая төгрөг
- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулахад 16.6 сая төгрөг
- Хяналт шалгалт, дотоод албан томилолтод 12.3 сая төгрөг
- Бичиг хэргийн зардалд 3.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2. Тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн ангилал зэрэглэлд хамаарах албан тушаалтанд аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга хамаардаг бөгөөд нийт 80м2 өрөө тасалгаатай байна.

3. Архангай аймгийн ИТХ нь 163.7 сая төгрөгийн өртөг бүхий 2 суудлын автомашинтай бөгөөд жилийн шатахууны зардал 15.0 сая төгрөг, үндсэн орон тооны жолоочийн цалингийн зардалд 17.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Архангай аймгийн ИТХ нь орон нутгийн 2 ТВ, сонинтой хамтран ажилладаг бөгөөд үйлчилгээний төлбөрт 10.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллийг хугацаанд байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1.Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 % буюу 9.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

2.Төсвийн хөрөнгөөр 16.6 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.ИТХ-ын хороодын ажиллах журмын дагуу 3 хорооны ахлагчтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан боловч гэрээнд ажлын хөлсийг тусгаагүй, сар бүр ажлын гүйцэтгэлийг үнэлж баримтжуулаагүй урамшуулал олгох шийдвэр гараагүй байхад сар бүр тус бүр нь 0.8 сая төгрөг нийт 28.8 сая төгрөгийн цалин хөлс тооцож олгосон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажлын гэрээг хуульд заасны дагуу хийж, гүйцэтгэлийг үнэлж, цаашид алдаа зөрчил давтан гарахгүй ажиллах албан шаардлага хүргүүллээ.

4.Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардлын анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, зарим худалдан авалт хийсэн иргэн ААНБ-тай гэрээ байгуулан ажиллаагүй, тойрох хуудас тооцоо нийлсэн актаар хоорондын тооцоог үйлдэж баталгаажуулаагүй 22.1 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн

тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөх, томоохон худалдан авалт хийх аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, гэрээг дүгнэж, тооцоо үүсгэж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Архангай аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх СТА-аар Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж биелэлтийг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2021.05.21-ний өдрийн 74 тоот бичгээр хангуулан ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг шалгах

#### 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 115.2 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 37.2 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн материаллаг, 74.0 сая төгрөгийн материаллаг бус зөрчилд зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 4 албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 4.0 сая төгрөгийн алдаа нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 6.2 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад “Magic color” ХХК руу шилжүүлсэн 19.5 сая төгрөгийн 5500 ширхэг номыг бүртгэлд тусгаагүй, Алтан өрнөх тайж ХХК-аас худалдан авсан 3.1 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг орлогод аваагүй, ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд зориулан зарцуулсан 14.6 сая төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж бүртгэлд тусгууллаа.

##### 4.2 Албан шаардлага

2020 оны Цагдаагийн газрын үйл ажиллагааны 700 ш тайлангийн хэвлэлийн зардал болох 4.0 сая төгрөгийг Архангай амьдрал сонин руу шилжүүлсэн нь анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, нотлох баримтаар дэмжигдээгүй, үр ашиггүй зарцуулалт байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн

**Шийдвэрлэсэн нь:** Алдаа зөрчлийг давтан гарахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

##### 4.3 Зөвлөмж

**4.3.1** ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд зориулсан зарцуулсан 14.6 сая төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

**4.3.2** Тайлант онд ИТХ нь ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор дарга, ажлын алба, ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга гэсэн 14 орон тоотой үйл ажиллагаа явуулсан нь Сангийн яамнаас хянаж баталсан орон тооноос 3-аар илүү байна.

**Шийдвэрлэсэн нь.** 2022 оноос эхлэн 2021 Засгийн газрын 376 тоот "Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, аймаг сумын ИТХ-ын ажлын албаны орон тоо хязгаарыг тогтоох тухай"- тогтоолоор ИТХ-ын ажлын албыг 10 орон тоотой байхаар заасан байгаа тул тус тогтоолыг хэрэгжүүлэн батлагдсан цалингийн сан, орон тоонд ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Аймгийн ИТХ	5	41.2	1	37.2			1	4.0	2	
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Аймгийн ИТХ	4	74.0					4	74.0		
<b>НИЙТ ДҮН</b>		<b>8</b>	<b>115.2</b>	<b>1</b>	<b>37.2</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>74.0</b>	<b>2</b>	